

# САР ТУТМЫН МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ

## 2024/8

Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төв

Макро үзүүлэлт	Хэмжих нэгж	2024.VIII	2023.VIII	2024.VII	Өмнөх сараас	Өмнөх улирлаас	Оны эхнээс	Өнгөрсөн жилийн мөн үеэс
ДНБ 2024 оны 2-р улирал	их наяд ₮, оны үнээр	16.4	13.6	-	-	-	-	5.6% ▲
Инфляц	хувь	6.5	10	5.5	0.8% ▲	-	5.2% ▲	-3.5 нэгж хувиар ▼
Ажилгүйдлийн түвшин	хувь	3.9% 2024 оны У4	5.3% 2022 оны У4	3.9% 2024 оны У4	-	-1.3% ▼ нэгж хувиар	-	-1.4% ▼ нэгж хувиар
Төсвийн тэнцэл	тэрбум ₮, өссөн дүнгээр	1572	1818	1573	-1 ▼	-	-	-246 ▼
Ам.долларын ханш	төгрөг	3380.98	3469.98	3380.86	0.12 ▲	-	-	-89 ▼
Гадаад худалдааны тэнцэл	сая ам.доллар, өссөн дүнгээр	3123.5	4057	2854	269 ▲	-	-	-933 ▼
Нүүрсний экспорт	сая тонн, өссөн дүнгээр	53.7	42.6	46.1	-	-	-	11.1 ▲
Зэсийн экспорт	мян.тонн, өссөн дүнгээр	1039.2	1022.3	927.6	-	-	-	16.9
Төв банкны бодлогын хүү	хувь	11%	13%	11%	-1%	-	0%	-2%
Гадаад валютын нөөц	тэрбум ам.доллар	4.7	3.9	4.37	-0.69% ▼	-	-	19.8% ▲
Чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь	хувь	5.73%	8.59%	5.87%	-0.14 нэгж хувиар ▼	-	-	-2.86 нэгж хувиар ▼

### ОНЦЛОХ СТАТИСТИК:

Монгол Улсын 2025 оны улсын төсвийг Засгийн газарт өргөн мэдүүллээ.	Төсвийн төсөлд Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээг 33.9 их наяд төгрөг буюу ДНБ-ий 35.6 хувь, нийт зарлагын хэмжээг 35.8 их наяд төгрөг буюу 37.7 хувь, төсвийн суурь тэнцлийг 1.9 их наяд төгрөг буюу ДНБ-ий 2 хувьтай тэнцүү ашигтай байхаар төлөвлөлөө.
---	---

### МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ОНЦЛОХ ШИЙДВЭРҮҮД:


Шийдвэрүүд	Огноо	Зорилго, үр дүн
Монгол Улсын зээлжих зэрэглэлийн үнэлгээ ахив	2024/09/18	Фитч агентлаг Монгол Улсын зээлжих зэрэглэлийг 2015 онд “В+” үнэлгээнээс “В” үнэлгээтэй болгож бууруулсан ба үүнээс хойш анх удаа үнэлгээг “В+” болгон нэмэгдүүллээ.

### МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

#### График


#### Нөлөөлөл

#### Инфляц




Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2024 оны 8 дугаар сард улсын хэмжээнд өмнөх оны мөн үеэс 6.5 хувь, өмнөх оны эцсээс 5.2 хувь, өмнөх сараас 0.8 хувиар өссөн байна. 2024 оны 8 дугаар сард өмнөх оны мөн үетэй харьцуулахад хүнсний барааны бүлгийн үнэ 7.2 хувиар, хүнсний бус барааны бүлгийн үнэ 6.2 хувиар, барааны бүлгийн үнэ 5.9 хувиар, үйлчилгээний бүлгийн үнэ 8.5 хувиар өсжээ.

#### Валютын ханш




Америк долларын ханш 2024 оны 8 дугаар сард 3380.98 төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 89 төгрөгөөр, өмнөх сараас 0.12 төгрөгөөр тус тус суларсан байна. Гадаад валютын нийт албан нөөц өмнөх сараас -0.69%-р буурч, өнгөрсөн жилийн мөн үеэс 19.8%-р өсөж, 4.70 тэрбум ам.долларт хүрэв.

#### Улсын төсөв



Улсын нэгдсэн төсвийн нийт орлого, тусламжийн хэмжээ 2024 оны эхний 8 сарын урьдчилсан гүйцэтгэлээр 19.9 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 4.6 (30.4%) их наяд төгрөг, тэнцвэржүүлсэн орлого тусламжийн хэмжээ 18.9 их наяд төгрөгт хүрч, 4.3 (29.3%) их наяд төгрөгөөр тус тус өссөн байна. Татварын нийт орлого 2024 оны эхний 8 сард 17.7 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 4.1 (29.9%) их наяд төгрөгөөр өсөхөд орлогын албан татварын орлого 2.2 (57.3%) их наяд төгрөг, нэмэгдсэн өртгийн албан татвар 823.7 (28.1%) тэрбум төгрөг, онцгой албан татвар 196.5 (37.2%) тэрбум төгрөгөөр тус тус өссөн нь голлон нөлөөлжээ.

#### Гадаад худалдаа



Монгол Улс 2024 оны эхний 8 сард нийт 155 улстай худалдаа хийж, гадаад худалдааны нийт бараа эргэлт 18.1 тэрбум ам.долларт хүрсэн байна. Үүнээс экспорт 10.6 тэрбум ам.доллар, импорт 7.5 тэрбум ам.долларт хүрч, тэнцэл 3.1 тэрбум ам.долларын ашигтай гарчээ. Экспорт 2024 оны эхний 8 сард өмнөх оны мөн үеэс 620.0 сая ам.доллаар өсөхөд нүүрс 372.5 сая ам.доллар, зэсийн баяжмал 195.9 сая ам.доллар, боловсруулаагүй буюу хагас боловсруулсан алт 159.7 сая ам.доллаар тус тус өссөн нь голлон нөлөөлжээ. Харин цайрын хүдэр, баяжмал 68.3 сая ам.доллар, лаазалсан махан бүтээгдэхүүн 50.1 сая ам.доллаар буурсан байна.

#### Дэлхийн эдийн засагт

- 2024 онд Монгол Улсын эдийн засаг 5.9 хувь өснө. Эх үүсвэр: Азийн хөгжлийн банк
- Дэлхийн банкнаас Монгол Улсын эдийн засгийг 6.2% өснө гэж таамаглажээ.
- БНХАУ-ын эдийн засаг 2023 онд 5.2% өсөв.

Эх сурвалж:

1. [Статистикийн бюллетень, 7-р сар 2024 он, Үндэсний статистикийн хороо](#)
2. [Статистикийн бюллетень, 7-р сар 2024 он, Монголбанк](#)
3. [www.1212.mn](http://www.1212.mn), [www.mongolbank.mn](http://www.mongolbank.mn)